

Нэгдсэн бодлого, төлөвлөлтийн газар (нэгжийн нэр)-н Нийгмийн халамжийн бодлого, төлөвлөлт, хууль тогтоомж хариуцсан ахлах шинжээч (албан тушаалын нэр)Доржсүрэнгийн Гэрэлтуяагийн (албан хаагчийн овог, нэр)-н 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТАЙЛАН

Нэг. Гүйцэтгэлийн зорилт, арга хэмжээний биелэлт

Д/д	Зорилтыг хэрэгжүүлэх арга хэмжээ	Шалгуур үзүүлэлт	Гүйцэтгэлийн түвшин					Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлтийн хувь	
			Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)					
	1	2	3	4	5	6	7			
Зорилт 1. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ “Нийгмийн халамжийг зорилтот бүлэгт чиглүүлэх, халамжийн мөнгөн дүнг нэмэгдүүлэх, орчин үеийн стандартыг нэвтрүүлэх зорилгоор эрх зүйн шинэчлэл хийж, хэрэгжүүлнэ.”										
					Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын үйл ажиллагааны өнгөрсөн хугацаанд хэрэгжүүлсэн бодлого, үр дүнд судалгаа, шинжилгээ хийж, үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх бодлогын зөвлөмж гаргах зорилгоор тус яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн “Ажлын хэсэг байгуулах, ажлын даалгавар батлах тухай” А/01 дүгээр тушаалаар “Нийгмийн халамжийн салбарын бодлогод үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх бодлогын зөвлөмж гаргах” ажлын хэсгийг 13 хүний бүрэлдэхүүнтэйгээр байгуулсан. Ажлын хэсэг халамжийн салбарын 15 асуудлыг тодорхойлж, тэдгээрийн өнөөгийн байдал, тулгамдсан асуудал, нийгэм эдийн засагт үзүүлсэн үр нөлөөг бусад улс орны туршлага, ололттой харьцуулсан судалж, ажлын хэсгийн дүгнэлт, санал зөвлөмжийг гаргаж, удирдамжид заасны дагуу 2024 оны 9 дүгээр сарын 05-ны өдөр ГБХНХ-ын сайд, яамны удирдлагуудад танилцуулсан.					
1.	Арга хэмжээ 1.1 “Нийгмийн халамжийн салбарын бодлогод үнэлэлт дүгнэлт өгч, цаашид авч хэрэгжүүлэх бодлогын зөвлөмж гаргах” ажлын хэсэгт ажиллах, бодлогын зөвлөмж боловсруулна.	100%	0%	20%		08-10				

Арга хэмжээ 1.2 Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөнд нийгмийн халамжийн чиглэлээр хэрэгжүүлэх арга хэмжээ, шалгуур үзүүлэлт, хүрэх үр дүнг боловсруулна.	100%	0%	100%	Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт нийгмийн халамжийн чиглэлийн 8 зорилт тусгагдсан. Эдгээр зорилтын хүрээнд ирэх 4 жилд нийт 18 арга хэмжээ хэрэгжүүлэхээр санал боловсруулж төлөвлөгөөний төсөлд тусгасан. Түүнчлэн тухайн арга хэмжээ тус бүрээр хөтөлбөрийн болон ТЕЗ-ийн үрд үнгийн үзүүлэлтийг шалгуур үзүүлэх, суурь болон зорилтот түвшний үзүүлэлтийн хамт боловсруулав.	10-12
Арга хэмжээ 1.3 Салбарын статистик үзүүлэлтэд тусгах нийгмийн халамжийн статистик үзүүлэлтийг шинэчлэн боловсруулна.	100%	0%	100%	Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын салбарын статистик үзүүлэлтэд тусгах нийгмийн халамжийн статистик үзүүлэлтийг олон улсад харьцуулахад үзүүлэлтүүдийн хамт яамны ХБГ-ын халамжийн хэлтэстэй хамтран боловсруулсан. Тухайлбал, Дэлхийн бусад улс орнуудын нийгмийн хамгааллын зардлын ДНБ-нд эзлэх хувь, Монгол Удсын эзлэх хувь, нийгмийн халамжийн зардлын ДНБ-нд болон улсын нэгдсэн төсөвт эзлэх хувь гэх зэргээ болон халамжийн 12 хөтөлбөрийг зарим задаргаагаар 2020-2024 оны статистик мэдээллийн хамт боловсруулав.	10-11
Арга хэмжээ 1.4 Улсын Их Хурлын даргын 2024 оны 97 дугаар захирамжаар байгуулсан "Нийгмийн халамжийн тухай хуулийн хэрэгжилттэй танилцаж, нийгмийн халамжийн тогтолцоог оновчтой болгох чиглэлээр санал, дүгнэлт гаргах ажлын хэсэгт ажиллах, холбогдох мэдээллийг боловсруулж хүргүүлнэ.	100%	0%	100%	УИХ-ын гишүүн Б.Жаргалангаас ирүүлсэн хүсэлтийн дагуу Нийгмийн халамжийн салбарын өнөөгийн байдал, хууль тогтоомжийн хэрэгжилтийн талаарх танилцуулгыг 2009-2023 оны халамжийн сангийн тайлан, 2020-2023 оны төсвийн мэдээллийн хамт тус тус бэлтгэн ГБХНХ-ын сайдын 2024 оны 9 дүгээр сарын 27-ны өдрийн 1/704 дүгээр албан бичгээр хүргүүлэв. Түүнчлэн 10 дугаар сарын 15-ны өдөр болсон уг ажлын хэсгийн хуралд ТНБД Л.Мөнхзул, Халамжийн хэлтсийн дарга Ю.Отгонбилэг, ахлах шинжээч Д.Гэрэлтуяа нар оролцож, "Нийгмийн халамжийн шинэчлэл"-ийн талаар мэдээлэл өгч, байнгын хорооны гишүүдээс гарсан асуултад хариулт өгч ажиллав.	9-10
Арга хэмжээ 1.5 Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл боловсруулах ажлын хэсэгт ажиллах	100%	50%	50%	Нийгмийн халамжийн тухай хуулийн шинэчилсэн найруулгын төсөл, Хүүхэд, гэр бүлд тэтгэмж, хөнгөлөлт үзүүлэх, олон хүүхэдтэй эхийг урамшуулах тухай хуулийн төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандах судалгааг хийж, хуулийн төслүүдийн үзэл баримтлалын төслүүдийг боловсруулав. ХНХ-ын сайд уг хуулийн төслүүдийн үзэл баримтлалыг Сангийн сайдтай 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдөр, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 2024 оны 6 дугаар сарын 07-ны өдөр хамтран батлав.	

					Яамны бүтэц, чиг үүрэг өөрчлөгдсөнтэй холбоотой хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллаж байна. Ажлын хэсэг Нийгмийн халамжийн үйлчилгээний тухай хуулийн төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулан, тандан судалгааны хамт ХЗДХЯ-нд батлуулахаар сайдын 2024 оны 11 дүгээр сарын 11-ний өдрийн 1/1195 дугаар албан бичгээр хүргүүлсэн. Хуулийн төсөл боловсруулах ажлын хэсгийн хурал, вакум уулзалтад оролцож ажиллаж байна.		
2.	Арга хэмжээ 1.6. Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах Засгийн газрын тогтоолын төсөл, журмын төслийг боловсруулах, Засгийн газрын хуралдаанаар батлуулна.	100%	0%	100%	Хүүхдийн мөнгөн тэтгэмж олгох журамд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай Засгийн газрын тогтоолын төслийг 3 дугаар сарын 20-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 121 дүгээр тогтоолоор батлуулна. Уг тогтоол батлагдсанаар асрамжийн газарт амьдарч байгаа 14-өөс дээш насны хүүхэд бүр хүүхдийн мөнгөний 20 хувийг картаар авч хичээлийн хэрэгсэл авах, секц, дугуйланд хамрагдах зэргээр өөрийн хөгжлийн хэрэгцээнд зарцуулах боломж бүрдсэн.	01-06	
3.	Арга хэмжээ 1.7. Алдар цолтон ахмад настанд олгох нэмэгдлийн хэмжээг нэмэгдүүлэх Улсын Их Хурлын тогтоолын төслийг боловсруулна.	100%	0%	20%	Алдар цолтон ахмад настанд олгох нэмэгдлийн хэмжээг нэмэгдүүлэх зорилгоор "Нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийн хэрэгцээ шаардлагыг урьдчилан тандах судалгааг хийж, тогтоолын төслийн үзэл баримтлалын төслийг боловсруулав. ХНХ-ын сайд уг тогтоолын төслүүдийн үзэл баримтлалыг Сангийн сайдтай 2024 оны 05 дугаар сарын 29-ний өдөр, Хууль зүй, дотоод хэргийн сайдтай 2024 оны 6 дугаар сарын 06-ны өдөр хамтран батлав. Батлагдсан үзэл баримтлалд нийцүүлэн "Нэмэгдлийн хэмжээг шинэчлэн тогтоох тухай" Улсын Их Хурлын тогтоолын төслийг дэлгэрэнгүй танилцуулга, зардлын тооцоо, үр нөлөөний судалгааны хамт боловсруулан Засгийн газрын гишүүдээс санал авахаар ХНХ-ын сайдын 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн 01/1674 дугаар албан бичгээр хүргүүлэв. Засгийн газрын бүтэц бүрэлдэхүүн өөрчлөгдсөн тул Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээгүй.	05-12	
4.	Арга хэмжээ 1.8. "Эхийн алдар" одонтой эхэд жилд нэг удаа олгох мөнгөн тусламжийн хэмжээг нэмэгдүүлэх Засгийн газрын тогтоолын төслийг	100%	0%	100%	Олон хүүхэд төрүүлж, өсгөж байгаа эхчүүдийн нийгмийн хамгааллыг сайжруулах зорилгоор "Эхийн алдар" одонтой эхийн мөнгөн тусламжийн хэмжээг Монгол Улсын төсвийн нөхцөл, боломжтой уялдуулан 2025 оноос 2 дахин нэмэгдүүлэх буюу Эхийн алдар 1 дүгээр зэргийн одонтой	01-06	

	боловсруулж, Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлнэ.				эхэд жилд нэг удаа 200.0 мянган төгрөг олгож байсныг 400.0 мянган төгрөг, 2 дугаар зэргийн одонтой эхэд 100.0 мянган төгрөг олгож байсныг 200.0 мянган төгрөг болгож тус тус нэмэгдүүлэх асуудлыг 2024 оны 06 дугаар сарын 06-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлэн, Засгийн газрын 225 дугаар тогтоолоор батлуулав. Мөнгөн тусламжийн хэмжээг 2 дахин нэмэгдүүлэхэд жилд 31.5 тэрбум төгрөг нэмж шаардагдах бөгөөд уг хөрөнгийн эх үүсвэрийг 2025 оны төсөвт тусган батлуулав. Засгийн газрын хуралдааны дараах хэвлэлийн хурлын мэдээллийг сайд, удирдлагад бэлтгэж өгөв.		
5.	Арга хэмжээ 1.9. 0-3 насны хүүхэд асарсны тэтгэмжийг шинэчлэх саналын хувилбар, танилцуулга, төсвийн тооцоолол боловсруулна. 0-3 насны хүүхэд асарсны тэтгэмжийн мөнгөн дүнг нэмэгдүүлэх Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулна.	100%	0%	80%	Цалинтай ээж буюу 0-3 насны хүүхэд асарсны тэтгэмжийг шинэчлэх саналын 3 хувилбар, танилцуулга, төсвийн тооцооллыг боловсруулан сайд, удирдлагад танилцуулав. 0-3 насны хүүхэд асарсны тэтгэмжийн мөнгөн дүнг нэмэгдүүлэх зорилгоор "Тогтоолд өөрчлөлт оруулах тухай" Засгийн газрын тогтоолын төсөл, танилцуулгыг холбогдох тооцооны хамт боловсруулан Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын 2024 оны 5 дугаар сарын 14-ний өдрийн 01/1440 дугаар албан бичгээр санал авахаар хүргүүлэв. Тогтоолын төсөлд тэтгэмжийн хэмжээг 150 мянган төгрөгт хүргэж нэмэгдүүлэхээр тусгав. Засгийн газрын гишүүдээс ирсэн саналд Сангийн яамны санал дэмжээгүй ирсэн тул Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлээгүй болно.	01-06	
Зорилт 2. ХӨДӨЛМӨР, НИЙГМИЙН ХАМГААЛЛЫН ЯАМНЫ 2024 ОНЫ ГҮЙЦЭТГЭЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨ "Нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээг нэмэгдүүлнэ."							
1.	Арга хэмжээ 2.1. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж хэмжээг нэмэгдүүлэх тооцоо боловсруулах, Засгийн газрын хуралдаанаар батлуулна.	100%	0%	100%	Монгол Улсын 2024 оны төсөвт нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэхэд зориулж 60.9 тэрбум төгрөгийн хөрөнгийг баталсан. Имйд хүн амын амьжиргааны доод түвшиний өсөлт болон батлагдсан төсөвтэй уялдуулан нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийг нэмэгдүүлэх хувилбар тооцооллыг хийж, халамжийн тэтгэврийг 15 хувь, асаргааны тэтгэмжийг 10 хувиар нэмэгдүүлэхээр Засгийн газрын тогтоолын төслийг боловсруулж, уг тогтоолын төслийг 2024 оны 3 дугаар сарын 20-ны өдрийн Засгийн газрын хуралдаанаар хэлэлцүүлж, Засгийн газрын 122 дугаар тогтоолоор батлууллаа. Энэ тогтоол батлагдсанаар нийгмийн халамжийн тэтгэврийн хэмжээ 50 мянган төгрөгөөр нэмэгдэж 375 мянга, асаргааны	01-06	

						тэтгэмжийн хэмжээ 10 хувиар нэмэгдэж 302.5 мянган төгрөгт хүрэв. Засгийн газрын хуралдааны дараах хэвлэлийн хурлын мэдээллийг сайд, удирдлагад бэлтгэж өгөв.		
	Арга хэмжээ 2.2. Халамжийн тэтгэвэр, тэтгэмж, бусад хөнгөлөлт, тусламжийн хэмжээг нэмэгдүүлэх, шинэчлэх, зардлын тооцоо, хувилбар боловсруулах, холбогдох саналыг 2025 оны төсвийн төсөлд тусгана.	100%	0%	100%		Монгол Улсын 2025 оны төсвийн хүрээний мэдэгдэл, 2025-2027 оны төсвийн төсөөлөлд нийгмийн халамжийн сангийн төсөвт тусгах шаардлагатай хөтөлбөр, арга хэмжээний төсвийн саналыг боловсруулж өгөв. Тухайлбал, 2025-2025-2027 онд инфляцын түвшин, хүн амын амьжиргааны доод түвшинтэй уялдуулан нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмжийн хэмжээг нэмэгдүүлэх, мөнгөн дүнг зайлшгүй нэмэгдүүлэх шаардлагатай хүнсний эрхийн бичиг, байнгын асаргаатай ахмад настан, хөгжлийн бэрхшээтэй иргэдийн улирлын тэтгэмж, ахмад настны амралт сувилалд амрах эрхийн бичгийн үнийн хөнгөлөлт зэрэг халамжийн хөтөлбөрүүдийн зардлыг нэмэгдүүлэх санал, төсвийн тооцооллыг боловсруулсан. Төсвийн хязгаарын саналд дээрх арга хэмжээнээс гадна эхийн алдар одонтой эхийн мөнгөн тусламжийг 2 дахин, алдар цолтон ахмад настанд төрөөс олгох нэмэгдлийг 2 дахин нэмэгдүүлэх санал, төсвийн тооцоог нэмж тусгасан.	04-08	
Зорилт 3. Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны 2024 оны гүйцэтгэлийн төлөвлөгөө “.....гадаад харилцаа хамтын ажиллагааг хөгжүүлэх, олон нийттэй харилцах..... зорилтын хүрээнд.”								
1.	Арга хэмжээ 3.1. “Нийгмийн халамжийн түүхэн хөгжил” номын агуулгыг хянах, шаардлагатай тайлбар мэдээллийг нэмж сайжруулах, хэвлүүлнэ.	100%	0%	80%		Монгол Улсад ахмадын асрамжийн байгууллага үүсэж, хөгжсөний 100 жилийн ойд зориулан “Нийгмийн халамжийн түүхэн хөгжил” номын агуулгыг хянаж, эцэслэн 300% хэвлүүлэхээр сонгогдсон хэвлэлийн компанид хүргүүлэв. Уг номын өмнөх үг, Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдын сайдын мэндчилгээний үгийг бэлтгэв.	01-08	
2.	Арга хэмжээ 3.2. “Нийгмийн халамжийн тогтолцоо” олон улсын хэлэлцүүлэг зохион байгуулна.	100%	0%	0%		Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайд Х.Булгантуяа 2023 оны 11 дүгээр сард Азийн хөгжлийн банкны гүйцэтгэх захирал Жастин Диокно-Сикат тэргүүтэй төлөөлөгчидтэй уулзаж, Монгол Улсад нийгмийн хамгааллын чиглэлээр олон улсын хурал зохион байгуулахаар ярилцсан. Түүнчлэн АХБ-ны Зүүн Азийн газрын Ерөнхий захирлын зөвлөх Кэлли Бөрд 2024 оны 1 дүгээр сард манай яамны холбогдох удирдлагуудтай уулзаж уг хурлыг зохион байгуулах хугацааг нарийвчлан ярилцсаны дагуу Монгол Улсад зохион байгуулах “Нийгмийн хамгааллын олон улсын онол-практикийн бага хурал”-ыг 2024 оны 10 дугаар сард 10 дугаар сарын 29,30-ны өдөр Улаанбаатар хотод амжилттай зохион байгуулна. Уг хуралд Азийн хөгжлийн банкны гишүүн орнууд болох Азербайжан, Пакистан, Филиппин,	06-12	

							Индонез, Узбекистан улсын 16 төлөөлөгч, АХБ болон яам, агентлагын удирдах, гүйцэтгэх албан тушаалтнууд оролцож, харилцан хоорондоо туршлага солилцсон. Монгол Улсад 2008 оноос хойш хэрэгжиж сайн жишээ болж байгаа "Хүнсний эрхийн бичгийн хөтөлбөр", 2022 оноос хэрэгжүүлж байгаа "Төгсөлтийн аргачлалын туршилтын хөтөлбөр"-ийн туршлага, ололтыг танлцуулсан. Тус форумын 2 дахь өдөр дээрх 5 улс орны 16 төлөөлөл, АХБ, яамны төлөөллүүд Баянзүрх дүүрэг ажиллаж, хүнсний эрхийн бичиг болон туршилтын хөтөлбөрт хамрагдсан өрхүүдийн амьдрал, тэдний үйлдвэрлэсэн бүтээгдэхүүн үйлдвэрлэлтэй танилцаж, худалдан авалт хийсэн.	
--	--	--	--	--	--	--	---	--

Нэмэлт үүрэг даалгавар (арга хэмжээ)-ын биелэлт

Д/д	Үүрэг даалгавар (арга хэмжээ)	Шалгуур үзүүлэлт	Суурь түвшин	Хүрэх түвшин	Хүрсэн түвшин (биелэлт)	Эхэлсэн, дууссан хугацаа	Биелэлт ийн хувь
1.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 1. Захиргааны хэм хэмжээний актыг бууруулахтай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг үзэл баримтлал, танилцуулгын хамт боловсруулан ажлын хэсэгт хүргүүлэв.	100%	0%	100%	Захиргааны хэм хэмжээний актыг бууруулахтай холбоотойгоор хууль хоорондын давхардал, хийдэл, зөрчлийг арилгах зорилгоор Нийгмийн халамжийн тухай хуульд өөрчлөлт оруулах тухай хууль, гэр бүлийн хүчирхийлэлтэй тэмцэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай, Хүнсний тухай хуульд өөрчлөлт оруулах тухай зэрэг хуулийн төслийг үзэл баримтлал, танилцуулгын хамт боловсруулан ажлын хэсэгт хүргүүлэв.	02-03	
2.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 2. ҮАГ-аас хийсэн гүйцэтгэлийн аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө гаргах, биелэлтийг хугацаанд нь хүргүүлнэ.	100%	100%	0%	ҮАГ-аас 2023 онд нийгмийн халамжийн бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудит хийсэн. Энэ хүрээнд 3 зорилт, 11 арга хэмжээг төлөвлөн "Нийгмийн халамжийн бодлого, стратегийн арга хэмжээний төлөвлөлт, түүний үр нөлөөнд хийсэн гүйцэтгэлийн аудитын зөвлөмжийг хэрэгжүүлэх төлөвлөгөө"-г 2024 оны 01 дүгээр сарын 23-ны өдөр Хөдөлмөр, нийгмийн хамгааллын сайдаар батлуулав. Уг төлөвлөгөөг ХНХСайдын 2024 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 01/241 дүгээр албан бичгээр ҮАГ-т хүргүүлсэн. Улмаар уг төлөвлөгөөний биелэлтийг гарган Төрийн аудитын тухай хуульд заасны дагуу ХНХ-ын	01-05	

						сайдын 2024 оны 04 дүгээр сарын 30-ны өдрийн 01/1252 дугаар албан бичгээр хүргүүлж ажиллав.			
						- Хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны Төрийн нарийн бичгийн даргын 2024 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн А/46 дугаар тушаалаар Яамны зохион байгуулалтын бүтцийн нэгжийн үйл ажиллагааны чиг үүргийн хуваарь шинэчлэн батлагдсантай холбогдон бүтцийн нэгж, албан тушаалд чиг үүргийн шинжилгээ хийх ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллав. Энэ хүрээнд нийгмийн халамжийн чиг үүргийг хэрэгжүүлж байгаа нэгж, албан тушаалд чиг үүргийн шинжилгээг бодлого боловсруулах болон бодлогыг хэрэгжүүлэх гэсэн 2 чиглэлээр хийв. Түүнчлэн яамны шинэ бүтцийн дагуу нийгмийн халамжийн бодлогын болон хэрэгжилтийн чиг үүргийг шинээр боловсруулж, энэ чиг үүргийн дагуу 8 албан тушаалтны албан тушаалын тодорхойлолтыг боловсруулж ажлын хэсэгт хүлээлгэж өгөв. - Засгийн газрын 2024 оны 8 дугаар сарын 14-ний өдрийн 37 дугаар тогтоолоор Гэр бүл, хөдөлмөр, нийгмийн хамгааллын яамны үйл ажиллагааны стратеги, зохион байгуулалтын бүтцийн өөрчлөлтийн хөтөлбөр батлагдсантай холбоотой яамны албан хаагчдын албан тушаалын тодорхойлолт боловсруулах ажлын хэсэгт ажиллаж, НБТГ-ын албан хаагчдын албан тушаалын тодорхойлолтыг боловсруулав.	03-09		
3.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 3. ХНХЯ-ны бүтцийн нэгжүүдийн чиг үүргийн шинжилгээ хийх ажлын хэсэгт ажиллах, нийгмийн халамжийн чиг үүргийг шинэчлэх, АТТ-ыг боловсруулна.	100%	50%	50%					
4.	Үүрэг даалгавар (арга хэмжээ) 4. Эрүүдэн шүүх болон бусад хэлбэрээр хэрцгий, хүнлэг бусаар буюу хүний нэр төрийг доромжлон харьцаж шийтгэхийн эсрэг конвенцийн хэрэгжилтийн талаарх Монгол Улсын гуравдугаар тайлан хамгаалах ажлын хэсгийн бүрэлдэхүүнд ажиллав.	100%	0%	100%					10-11

1.	Арга хэмжээ 1. Нийгмийн халамжийн чиглэлээр бусад оронд авч хэрэгжүүлсэн арга хэмжээ, дотоодын болон олон улсын байгууллагын судалгааны материалуудыг уншиж судлах	100%	0%	100%	Нийгмийн халамжийн хуулийн төслийг боловсруулахтай холбогдуулан дэлхийн улс орнуудын туршлагыг судалсан. Тухайлбал, Франц, Белги, Австри зэрэг дэлхийн өндөр хөгжилтэй орнууд хүүхдийн тоо, эцэг эхийн орлогоос хамаарч тэтгэмж, тусламж олгох, олон хүүхэдтэй гэр бүлд татварын хөнгөлөлт үзүүлэх, орон сууцтай болох, өрхийн аж ахуйтай болоход нь хөнгөлөлттэй зээл өгөх арга хэмжээг судалсан. Нийгмийн халамжийн хуулийн шинэчлэлийг боловсруулахад дэмжлэг үзүүлж ажиллаж байгаа зөвлөхийн боловсруулсан Орос, Польш, Унгар, Франц, Армен зэрэг 14 улсын туршлагыг уншиж судлан хуулийн төслийг боловсруулахад ашиглав.	01-12	
2	Арга хэмжээ 2. Хариуцсан асуудлын чиглэлээр зохих сургалтанд хамрагдах	100%	0%	100%	Удирдлагын академийн эрхэлсэн түшмэлийн багц сургалтад 2024 оны 9 дүгээр сарын 13-ны өдрөөс 11 дүгээр сарын 29-ны өдрийг дуусталх хугацаанд суралцаж, төгссөн.	01-12	

ТАЙЛАН ГАРГАСАН:

Нийгмийн халамжийн бодлого,
төлөвлөлт, хууль тогтоомж хариуцсан
ахлах шинжээч
(Албан тушаал)

 / Д.Гэрэлтуяа /

(Нэр, гарын үсэг)

(Огноо)

2024 12.05